

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ орон сууц" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/11-НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 7036-3040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 7036-3036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Т.Мөнхзул  
Утас: 7036-3036 Цахим хаяг: [munkhzult@audit.gov.mn](mailto:munkhzult@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөл	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. Аудитын тайлан	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17-18

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХС	Аймаг хөгжүүлэх сан
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТАХ	Төрийн албан хаагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

И баг Цаглан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № СЭА-2023/11-НА-СТА-ОНА

тавай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь тайлант онд 751,085.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 675,061.2 мянган төгрөгийн зардал гарган 72,222.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

### Аудитын гол асуудал

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь тайлант онд төрийн албан хаагчдын 120 айлын орон сууцны зээлийн эргэн төлөлтөөс 732,924.4 мянган төгрөг, алдангийн орлого 4,347.6 мянган төгрөг, хүүгийн орлого 13,813.2 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлэн төлөвлөгөөний биелэлт 95.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагджээ.

Үйл ажиллагааны зардлыг 712,937.1 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 675,061.2 мянган төгрөгийг зарцуулж 37,875.9 мянган төгрөг буюу 5.3 хувийн хэмнэлттэй ажилласан байна.

Тус газарт Аймаг хөгжүүлэх сангаас олгосон 13 аж ахуйн нэгжийн 431,807.8 мянган төгрөгийн, 37 иргэний 539,949.2 мянган төгрөгийн , эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл тайлагнагдсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх ~~үндэслэлтэй~~ байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>610,003,279.10</b>	<b>847,559,671.11</b>
1.1.1	Арилжааны банк дахь харилцах	610,003,279.10	847,559,671.11
	<b>АВЛАГА</b>	<b>6,041,210,909.51</b>	<b>5,627,745,237.77</b>
1.1.2	Дансны авлага	4,275,177,346.63	4,106,745,324.89
1.1.3	Бусад авлага/ ажилчидтай холбогдсон авлага/	1,154,600.00	-
1.1.4	Бусад авлага/ байгууллагаас авах авлага/	1,156,262,660.00	981,242,660.00
1.1.5	Бусад авлага/ хувь хүнээс авах авлага/	608,616,302.88	539,757,252.88
1.1.6	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,651,214,188.61</b>	<b>6,475,304,908.88</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Машин тоног төхөөрөмж	2,799,999.00	2,799,999.00
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл	-1,679,999.40	-2,239,999.20
1.2.3	Тавилга эд хогшил	3,723,600.00	3,723,600.00
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл	-3,723,600.00	-3,723,600.00
1.2.5	Бусад эргэлтийн хөрөнгө	468,262,575.59	-
1.2.6	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>469,382,575.19</b>	<b>559,999.80</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,120,596,763.80</b>	<b>6,475,864,908.68</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		<b>11,974,279.72</b>
2.1.1.1	НДШ-ийн өглөг	82,316.58	1,356,969.63
2.1.1.2	Татварын өглөг	-	501,002.00
2.1.1.3	Урьдчилж орсон орлого	-	10,116,308.09
2.1.1.4	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>82,316.58</b>	<b>11,974,279.72</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат өр төлбөр	650,000,000.00	50,000,000.00
2.1.2.5	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>650,000,000.00</b>	<b>50,000,000.00</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>650,000,000.00</b>	<b>61,974,279.72</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-Орон нутгийн сан	908,960.00	908,960.00
2.3.2	Өмч:-Төрийн	4,338,060,572.22	4,338,060,572.22
2.3.3	Хуримтлагдсан ашиг	4,523,818,607.61	2,002,698,334.36
2.3.4	Тайлант үеийн ашиг/алдагдал/	-2,392,273,692.61	72,222,762.38
2.3.5	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>6,470,514,447.22</b>	<b>6,413,890,628.96</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,120,596,763.80</b>	<b>6,475,864,908.68</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	732,924,407.03
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг( алдагдал)	-	732,924,407.03
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүү/ алданги/-ийн орлого	12,685,431.50	18,160,817.21
6	Бусад орлого	1,623,001,453.78	-
7	Бусад орлого /УТХА орлого бараа материал/	1,118,992,368.10	-
8	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
9	Ерөнхий ба удирдлагын зардал	40,047,223.86	48,904,833.84
10	Санхүүгийн зардал	25,898,090.23	26,156,430.00
11	Бусад зардал	5,081,007,631.90	600,000,000.00
12	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-2,392,273,692.61	76,023,960.40
13	Орлогын татварын зардал	-	3,801,198.02
14	Татварын дараах ашиг (алдагдал)	-2,392,273,692.61	72,222,762.38
15	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
16	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-2,392,273,692.61	72,222,762.38

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/				
Код	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	908,960.00	4,523,818,607.61	4,524,727,567.61
3	Залруулсан үлдэгдэл	908,960.00	4,523,818,607.61	4,524,727,567.61
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-2,392,273,692.61	-2,392,273,692.61
5	Өмчид гарсан өөрчлөлт	4,338,060,572.22		-
6	Зарласан ногдол ашиг			-
7	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,338,969,532.22	2,131,544,915.00	6,470,514,447.22
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(128,846,580.64)	-
9	Залруулсан үлдэгдэл	4,338,969,532.22	2,002,698,334.36	6,470,514,447.22
10	Өмчид гарсан өөрчлөлт			
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		72,222,762.38	72,222,762.38
12	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,338,969,532.22	2,074,921,096.74	6,413,890,628.96

## 2.4 Мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>785,299,248.05</b>	<b>912,617,655.85</b>	
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого/ТӨҮГ/	772,613,816.55	894,456,838.64	
1.1.2	Татаас санхүүжилтийн орлого		-	
1.1.3	Хүүгийн орлого		-	
1.1.4	Бусад мөнгөн орлого	12,685,431.50	18,160,817.21	
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>67,286,373.29</b>	<b>75,061,263.84</b>	
1.2.1	Ажиллагчдад төлсөн цалин	32,112,382.28	43,329,386.35	
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,007,125.00	5,575,447.49	
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,723,820.00	4,168,530.00	
1.2.4	Бичиг хэргийн зардал			
1.2.5	Тээвэр шатахууны зардал	7,300,000.00	12,456,000.00	
1.2.6	шуудан холбооны зардал		-	
1.2.7	Дотоод албан томилолтын зардал			
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	12,676,666.01	600,000.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,466,380.00	8,931,900.00	
1.2.10	Банкны үйлчилгээний хураамж			
1.2.11	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр			
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>718,012,874.76</b>	<b>675,061,263.84</b>	
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>246,769,999.50</b>	<b>-</b>	
2.1.1	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	246,769,999.50	-	
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>683,475,691.00</b>	<b>600,000,000.00</b>	
2.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	683,475,691.00	600,000,000.00	
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-683,475,691.00</b>	<b>-600,000,000.00</b>	
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>281,307,183.26</b>	<b>237,556,392.01</b>	
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>328,696,095.84</b>	<b>610,003,279.10</b>	
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>610,003,279.10</b>	<b>847,559,671.11</b>	

## 2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2022 оны		/төгрөгөөр/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
A	Нийт орлогын дүн	788,047,777.36	751,085,224.24	36,962,553.12	95.0
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	778,047,777.36	732,924,407.03	45,123,370.33	94.0
2	Бусад орлого	10,000,000.00	18,160,817.21	8,160,817.21	182.0
3	АХС-ийн авлага барагдуулалт	150,000,000.00	239,547,050.00	89,547,050.00	160.0
B	Нийт зардлын дүн	112,937,172.00	75,061,263.84	37,875,908.16	66.0
1	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	-	-
2	б) Ерөнхий ба удирдлагын зардал	112,937,172.00	75,061,263.84	37,875,908.16	66.0
3	Үндсэн цалин	43,722,616.00	43,329,386.35	393,229.65	0.9
	Үр дүнгийн урамшуулал	4,493,229	-	-	-
4	Ажил олгогчоос төлөх НДШ	5,465,327.00	5,575,447.49	-110,120.49	102.0
5	Үндсэн үйл ажиллагааны зардал	59,256,000.00	26,156,430.00	33,099,570.00	44.0
6	Бичиг хэрэг	3,600,000.00	2,850,600.00	749,400.00	79.0
7	Тээвэр шатахуун	18,000,000.00	12,456,000.00	5,544,000.00	69.0
8	Сургалт семинарын зардал	1,000,000.00	-	1,000,000.00	
9	Шуудан холбооны зардал	840,000.00	-	840,000.00	-
10	Дотоод албан томилолт	6,816,000.00	2,890,000.00	3,926,000.00	42.0
11	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,500,000.00	-	2,500,000.00	-
12	Банкны үйлчилгээний хураамж	-	48,000.00	-48,000.00	-
13	Бараа үйлчилгээний бусад зардал	6,500,000.00	1,269,930.00	5,230,070.00	20.0
14	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	8,000,000.00	6,641,900.00	1,358,100.00	83.0
15	ТАХ-ын орон сууцны хөрөнгө оруулалтын зээлийн эргэн төлөлт	600,000,000.00	600,000,000.00	-	100.0
16	Нийт ашиг алдагдал	788,047,777.36	751,085,224.24	36,962,553.12	95.0

### **3. Санхүүгийн тайлангийн тодруулга**

#### **3.1 Байгууллагын үйл ажиллагаа**

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь “Сэлэнгэ аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилготойгоор ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх,
- Гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлээс санхүүжилтийн эх үүсвэр татах ажлыг олон хэлбэрээр зохион байгуулах замаар хөрөнгийн тогтвортой сан бүрдүүлж, барилгын хөрөнгө оруулалт, зээл санхүүжилтийг цогцоор нь шийдвэрлэх,
- Төрийн өмнөөс аймгийн нутаг дэвсгэрт орон сууц бариулах ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагатай орон сууц, үл хөдлөх хөрөнгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор гэрээгээр болон хамтарсан аж ахуйн нэгж байгуулах зарчмаар хамтран ажиллаж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх,
- Залуу гэр бүл болон төрийн албан хаагчдад чиглэсэн орон сууцжуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, урт хугацааны, хямд түрээсийн орон сууцны менежментийг хэрэгжүүлэх,
- Сумдын төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан эхлүүлэх гэх мэт.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

#### **3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 53 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх “Орон нутгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна” 20.1.9 дэх “орон сууц, нийтийн аж ахуй,” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Тус үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	610,003.3	847,559.7	237,556.4
Нийт авлага	6,041,210.9	5,627,745.2	-413,465.7
Авлага /орон сууц/	4,275,177.3	4,106,745.3	-168,432.0
Авлага /АХС/	1,766,033.9	1,520,999.9	-245,034.0
Бусад эргэлтийн хөрөнгө	468,262.6		-469,382.6
Үндсэн хөрөнгө	1,120.0	560.0	560.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,120,596.8</b>	<b>6,475,864.9</b>	<b>-644,731.9</b>
Богино хугацаат өр төлбөр	82.3	1,857.9	1,775.6

Урьдчилж орсон орлого	0.0	10,116.3	10,116.3
Урт хугацаат өр төлбөр	650,000.0	50,000.0	-600,000.0
Эздийн өмч	6,470,514.4	6,413,890.6	-56,623.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,120,596.8</b>	<b>6,475,864.9</b>	<b>-644,731.9</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 847,559.6 мянган төгрөг болж 237,556.3 мянган төгрөгөөр өссөн нь АХС-ийн авлагыг барагдуулсан болон ТАХ-ийн захиалгын байрны гэрээний дагуу төвлөрсөн орлогоос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 4,106,745.3 мянган төгрөг болж 168,432.0 мянган төгрөгөөр буурсан нь ТАХ-ийн 120 айлын орон сууцны доор байрлах 36 автомашины зогсоолыг гэрээ байгуулж борлуулсан 468,262.6 мянган төгрөгөөр, Баянгол сумын 3 орон сууцны 124,078.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТАХ-ийн 120 айлын орон сууцны эргэн төлөлтөөс 732,924.4 мянган төгрөг, Алтанбулаг болон Баянгол сумын орон сууцны эргэн төлөлтөөс 27,848.7 мянган төгрөг зэрэг нийт 760,773.1 мянган төгрөгийн авлага буурснаас шалтгаалсан байна.

АХС-ийн аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдээс авах авлага дансны үлдэгдэл 1,520,999.9 мянган төгрөг болж 234,034 мянган төгрөгөөр буурсан нь 2009-2016 онуудад АХС-аас ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон зээлээс 3 аж ахуйн нэгж байгууллагаас авах 175,020.0 мянган төгрөгөөр, иргэдээс авах авлага 70,014.0 мянган төгрөгөөр буурснаас тус тус шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл / анхны өртгөөр/ өөрчлөлт гараагүй байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,857.9 мянган төгрөг болж 1,775.6 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр үүссэнтэй холбоотой байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 10,116.3 мянган төгрөг болж өссөн нь төрийн албан хаагчийн орон сууцны тухайн жилд төлөгдөх гэрээний дүнгээс илүү төлөгдсөнөөс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 50,000.0 мянган төгрөг болж 600,000.0 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд "Бүрнээ Мөнхбат" ХХК, "Таванхан Уул" ХХК, "Сэлэнгэ орон сууц" ОНӨААТҮГ-ын байгуулсан гуравласан гэрээний дагуу 600,000.0 мянган төгрөгийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Эздийн өмч өр төлбөр дансны үлдэгдэл 6,475,864.9 мянган төгрөг болж 644,731.9 мянган төгрөгөөр буурсан нь урт хугацаат өр төлбөрийг 600,000.0 мянган төгрөгөөр бууруулсан, урьдчилж орсон орлого 10,116.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, эздийн өмч 56,623.8 мянган төгрөгөөр буурсан зэргээс тус тус шалтгаалжээ.

### **3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Сэлэнгэ орон сууц" ОНӨААТҮГ-ын захирал

нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ орон сууц ” ОНӨААТҮГ-ын 2022 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар захирамжаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтыг баталсан байна. Нийт орлогыг 788,047.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 712,937.1 мянган төгрөгөөр тогтоон баталсан байна.

Гүйцэтгэлээр 751,085.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 675,061.2 мянган төгрөгийн зардал гарган, 72,222.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 751,085.2 мянган төгрөг болж төлөвлөснөөс 36,962.5 мянган төгрөг дутуу буюу 95.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 675,061.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 37,875.9 мянган төгрөг буюу 5.3 хувиар хэмнэгдсэн нь цалин хөлс, шатахуун, албан томилолт, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, нэг удаагийн тэтгэмж зэрэг зардлуудын хэмнэлтээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 72,222.7 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь хүүгийн болон ТАХ-ийн орон сууцны эргэн төлөлтийн 751,085.2 мянган төгрөгийн орлого төвлөрсөн болон зардлыг 5.3 хувиар хэмнэснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав

#### **4. Аудитын тайлан**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ /цаашид “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүү байдлын тайлангийн нийт авлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүү байдлын тайлангийн нийт авлага 60,041,210.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 60,412.1 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

#### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.3.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 20 төрлийн 148 мэдээллээс 35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн боловч бүрэн хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбартай холбоотой мэдээллийг 8 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Дараа жилийн төсвийн төсөлтэй холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээтэй холбоотой мэдээллийг 8 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 8 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,

- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой мэдээллийг 8 удаа хугацаа хоцроож мэдээлсэн
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлантай холбоотой мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож мэдээлсэн гэх мэт

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/634 дүгээр албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд үйлдвэрлэлийн үр дүнгээр өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжийг хэрэгжүүлэн алдагдалгүй ашигтай ажиллах бүхий л бололцоог ханган ажиллах, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Дотоод албан томилолтыг 3,926.0 мянган төгрөгөөр,
- Тээвэр шатахууны зардлыг 5,544.0 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж урамшууллыг 2,500.0 мянган төгрөгөөр,
- Бичиг хэргийн зардлыг 749.4 мянган төгрөгөөр
- Сургалт семинар, шуудан холбооны зардлыг 1,840.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж,
- Нийт авлагыг 413.6 мянган төгрөгөөр бууруулан, 72,222.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

#### Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 135,282.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлагыг биелүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ оруулахтай холбоотой 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	137,282.5	3	137,282.5	100.0
Хариуцлага тооцох	1	-	1	-	100.0
Зөвлөмж	2	2,174.9	1	2,174.9	50.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>139,457.4</b>	<b>5</b>	<b>137,282.5</b>	<b>83.3</b>

## 4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

АХС-аас 2009-2016 оны хугацаанд их хэмжээний зээл авсан 4 аж ахуйн нэгжээс Алтанбилэг ХХК, Гурван тулгат цамхаг зэрэг 2 аж ахуйн нэгжийн зээл бүрэн төлөгдөж, “Ганмон Энжелс” ХХК-ийн зээлийн үлдэгдэл 2021 оны эцэст 720,000.0 мянган төгрөг байсан бол 170,688.0 мянган төгрөгийг барагдуулж, 549,312.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2021 оны 39 дүгээр тогтоолоор “Ганмон Энжелс” ХХК-ийн 720,000.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлээс 634,363.0 мянган төгрөгийн зээлийн төлбөрт Цагааннуур, Ерөө, Баянгол, Шаамар сумдад баригдсан орон сууцуудаас 13 орон сууц, 4 автомашины зогсоолыг шилжүүлэн тооцохоор шийдвэрлэснээс 170,688.0 мянган төгрөгийн үнэ бүхий Ерөө суманд 1 орон сууц, Баянгол суманд 3 орон сууцыг шилжүүлэн авч гэрээ хийн тайлант онд уг аж ахуйн нэгжийн зээлийн үлдэгдлээс хасаж тооцсон байна. Үлдсэн орон сууцуудыг үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг тус байгууллагын нэр дээр шилжүүлсний дараа авлагаас хасаж тооцохоор гэрээ хийсэн бөгөөд үлдэгдэл зээл, алдангийн 172,246.5 мянган төгрөгийг төлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага авлага барагдуулалтын ажиллагааг эхлүүлсэн байна.

Цаашид шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч үлдэгдэл авлагыг бүрэн барагдуулах нь зүйтэй юм.

- Нийслэл хүнс ХХК нь 2009 онд 300,000.0 мянган төгрөгийн зээл авснаас 2022 оны эцэст 72,800.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. 2018-2020 онуудад зээлийн эргэн төлөлтийг тогтмол хийж байсан боловч Ковид-19 цар тахлын үеэр үйл ажиллагаа тасалдаж жигдрээгүй гэх шалтгаанаар тайлант онд зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.
- Чагта ХХК-ийн 2009 онд авсан 50,000.0 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт огт хийгдээгүй бөгөөд Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлах хэсэгт 2 удаа нэхэмжлэл өгсөн боловч өмгөөлөгч хөлслөн авч зээлийг барагдуулахаас татгалзсан байна.
- Дээрхээс гадна 13 аж ахуйн нэгж 431,807.8 мянган төгрөгийн, 37 иргэн 539,949.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас ШШГГ-ын гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа 9 зээлдэгч байгаа бол хуулийн дагуу өв үүсэх эрхийн хугацаа хүлээгдэж буй 4 зээлдэгч, шүүхээр эвлэрлийн гэрээ байгуулсан 5 зээлдэгч, эрэн сурвалжилж байгаа 1 зээлдэгч, гадаадад байгаа 1 зээлдэгч байна.

Эдгээр зээлийн эргэн төлөлтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм.

## **5. Аудитын илрүүлэлт**

### **5.1 Залруулсан алдаа**

Аудитаар 10,116.3 мянган төгрөгийн урьдчилж орсон орлогыг авлага бууруулж бүртгэсэн алдааг залрууллаа.

Аудитаар нийт 49,821.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, 46,981.3 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 2,840.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### **5.2 Албан шаардлага**

**5.2.1** Төрийн албан хаагчтай байгуулсан орон сууц захиалгаар барих гэрээний үүргийн биелэлтийн дагуу төвлөрүүлэх орлогоос **20** албан хаагчийн **45,123.4** мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, Төрийн албан хаагчтай байгуулсан *“Орон сууц захиалгаар барих”* гэрээний 2.2 дахь *“Захиалагч нь үл хөдлөх эд хөрөнгийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хуваарийн дагуу төлнө”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийг биелэлтийг хангуулах албан шаардлага хүргүүлэх.

**5.2.2** Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ХХОАТ-ын 501.0 мянган төгрөгийн, НДШ-ийн 1,356.9 мянган төгрөгийн зэрэг нийт 1,857.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн

20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Зөвлөмж

### 5.1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд нийт 2,840.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь " ... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, **бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана.** ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж		
							Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агүй		Тоо	Дүн	
						Тоо	Дүн	Тоо	Дүн				
Санхүүгийн тайланд урьдчилж орсон орлогыг авлага бууруулж тайлагнасан	1	10,116.3	1	10,116.3			1	10,116.3					
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>10,116.3</b>	<b>1</b>	<b>10,116.3</b>	<b>1</b>		<b>1</b>	<b>10,116.3</b>					

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гэрээний үүргийн биелэлтийн дагуу төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн	1	45,123.4			1	45,123.4						
ХХОАТ, НДШ-ийн өглөг үүсгэсэн	1	1,857.9			1	1,857.9						
Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй							1	2,840.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>49,821.3</b>			<b>2</b>	<b>46,981.3</b>	<b>1</b>	<b>2,840.0</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	35				35			
Огт мэдээлээгүй								
<b>Дүн</b>	<b>35</b>				<b>35</b>			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>35</b>				<b>35</b>			

Аймаг хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагын жагсаалт  
/2022 оны жилийн эцсийн байдлаар/

АТММ  
Хэвлэл  
2022.12.31

№	Зээлдэгчийн нэрс	Байршил	Зээлийн зориулалт	Зээлийн хэмжээ	Зээл авсан он сар өдөр	Зээлийн үлдэгдэл
1	"Зэлтэр хүрхрээ" хоршоо С.Санжсүрэн	Түшиг	Тоосгоны үйлдвэрт тоног төхөөрөмж авах	30,000,000.00	3/19/2009	43171417,230,000.00
2	"Нийслэл хүнс трейд" ХХК захирал Ж.Эрдэнэбаяр	Сүхбаатар	Ногоо боловсруулах үйлдвэр байгуулах	300,000,000.00	4/23/2009	10,665,72,800,000.00
3	"Шим" ХК захирал Ж.Баярмагнай	Сүхбаатар	Сүү боловсруулах үйлдвэрт тоног төхөөрөмж авах	50,000,000.00	4/27/2009	40,000,000.00
4	"Бум-Эрдэнэ" ХХК захирал Ц.Төртогтох	Мандал	Усалгаатай тариалан эрхлэх	60,000,000.00	7/15/2009	34,000,000.00
5	"Төгс хөвгүүд" ХХК захирал П.Энхжаргал	Сүхбаатар	Халуун тогооны хоолны газар байгуулах	50,000,000.00	9/7/2009	48,000,000.00
6	"Арвин ургац цэцэглэнэ" хоршоо Г.Жаргалтуяа	Мандал	Хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмж авах	5,000,000.00	12/12/2009	695,080.00
7	"Тулгын тохой" ХХК захирал М.Бат-Ирээдүй	Мандал	Хорголжин тэжээлийн үйлдвэр байгуулах	30,000,000.00	4/23/2010	6,540,000.00
8	"Чагта" ХХК захирал Б.Баттулга	Алтанбулаг	Гурилын үйлдвэр байгуулах	50,000,000.00	5/10/2010	50,000,000.00
9	"Бага буурагчин" ХХК захирал Н.Баттулга	Ерөө	Хуурай өндөг үйлдвэрлэх	50,000,000.00	5/9/2011	38,300,000.00
10	"Мон-Апи" ХХК захирал Г.Бүрэнжаргал	Шаамар	Зөгийн аж ахуй шинэчлэх	15,000,000.00	5/27/2011	15,000,000.00
11	"Зүүвч ивэн бургалтай" ХХК захирал Н.Эрдэнэцогт	Баруунбүрэн	Гурилын үйлдвэр байгуулах	25,000,000.00	6/14/2011	23,418,000.00
12	"Сэлэнгэ буудай" ХХК захирал М.Шинэчулуун	Сүхбаатар	Тэжээлийн үйлдвэр байгуулах	30,000,000.00	4/23/2012	20,000,000.00
13	"БМОНС" ХХК захирал Э.Нарангэрэл	Сүхбаатар	Хүнсний ногоо даршлах цех байгуулах	15,000,000.00	5/22/2012	15,000,000.00
14	"Шижир долгио" ХХК захирал Д.Сандаг-Очир	Сайхан	Талх нарийн боовны цех байгуулах	13,000,000.00	7/4/2012	1,900,000.00
15	"Ганмон энжеле" ХХК	Сүхбаатар сум	Цагааннуур, Ерөө, Шаамар суманд тус бүр 25 айлын, Баянгол суманд 30 айлын орон сууц барих	720,000,000.00	9/16/2015	549,312,000.00
16	Урсгал ус ХХК	Сүхбаатар	Хоорондын тооцооны үлдэгдэл	93,000,000.00	1/1/2012	49,047,580.00
Нийт: Байгууллагаас авах авлагын үлдэгдэл						<b>981,242,660.00</b>
№	Зээлдэгчийн нэрс	Байршил	Зээлийн зориулалт	Зээлийн хэмжээ	Зээл авсан он сар өдөр	Зээлийн үлдэгдэл
1	Ш.Энхтуяа	Сүхбаатар	Төмс хүнсний ногоо тариалах	6,000,000.00	5/11/2009	5,500,000.00
2	Л.Хосбаяр	Сүхбаатар	Савлагдсан бэлэн буузны үйлдвэр байгуулах	15,000,000.00	7/15/2009	5,000,000.00
3	Д.Баяржаргал	Сүхбаатар	Сүү цагаан идээ үйлдвэрлэх	2,000,000.00	7/15/2009	2,000,000.00
4	Ш.Эрдэнэчимэг	Шаамар	Цементен блокны жижиг үйлдвэр байгуулах	10,000,000.00	9/21/2009	10,000,000.00
5	Б.Баттогтох	Баруунбүрэн	Аялал жуучлал, газар тариалан, мал аж ахуйн загвар погцолбор байгуулах	55,000,000.00	12/28/2009	37,500,000.00
6	Б.Мөнх-Эрдэнэ	Сүхбаатар	Монгол уламжлалт, эмнэлэг сувилал	20,000,000.00	12/29/2009	8,250,050.00
7	Нямсүрэн	Сүхбаатар	Чипс, попкорны газар байгуулах	20,000,000.00	4/27/2010	16,757,000.00
8	Ж.Зояа, Д.Энхцэцэг	Хушаат	Зайрмагны цех байгуулах	10,000,000.00	5/17/2010	10,000,000.00
9	Ч.Диваанансал	Сүхбаатар	Ясны гурил үйлдвэрлэх	25,000,000.00	7/16/2010	25,000,000.00
10	Д.Цэрэнхорол	Мандал	Оёдлын цех байгуулах	11,000,000.00	8/30/2010	6,172,168.00
11	Д.Эрхэмбаяр	Мандал	Чацаргана тариалах	20,000,000.00	5/23/2011	15,000,000.00
12	С.Арсланбаяр	Сант	Ахуйн үйлчилгээ байгуулах	30,000,000.00	5/26/2010	26,140,000.00
13	Э.Оюунсайхан	Шаамар	Модон материалын бэлдэц үйлдвэрлэх	5,000,000.00	7/18/2011	300,000.00

14	Б.Нарангэрэл	Хушаат	Жимс, жимсгэнэ боловсруулах цех байгуулах	10,000,000.00	7/26/2011	4,187,135.00
15	Г.Хүрэлхүү	Алтанбулаг	Хаягдал дугуй боловсруулах үйлдвэр байгуулах	30,000,000.00	9/2/2011	12,200,000.00
16	Д.Наранчимэг	Хүдэр	Цайны газар байгуулах	9,400,000.00	11/23/2011	2,447,900.00
17	Ж.Наранчимэг	Сүхбаатар	4-н улиралын хүлэмжийн аж ахуй байгуулах	50,000,000.00	11/23/2011	39,000,000.00
18	Ц.Тогтох	Сүхбаатар	Торгон хэвлэлийн үйлдвэр байгуулах	22,000,000.00	11/23/2011	15,930,000.00
19	Б.Ганчимэг	Сүхбаатар	Оймсны үйлдвэр байгуулах	20,000,000.00	11/23/2011	18,000,000.00
20	З.Загдсүрэн	Хушаат	Оёдлын цехийн өргөтгөл	10,000,000.00	12/6/2011	5,900,000.00
21	Б.Дарихжав	Сүхбаатар	Спорт хувцасны үйлдвэр байгуулах	15,000,000.00	2/21/2012	5,630,000.00
22	Т.Өлзий-Орших	Сүхбаатар	Мужааны цех байгуулах	20,000,000.00	2/29/2012	20,000,000.00
23	М.Батзориг	Сүхбаатар	Шахмал түлшний үйлдвэр байгуулах	20,000,000.00	3/6/2012	13,450,000.00
24	Л.Аззаяа	Улаанбаатар	Монгол гэрийн үйлдвэр байгуулах	25,000,000.00	4/12/2012	25,000,000.00
25	А.Цэрэндолгор	Сүхбаатар	Даршилсан ногоо боловсруулах цех байгуулах	20,000,000.00	4/10/2012	300,000.00
26	Б.Буянхишиг	Ерөө	Сүү хөргөлтийн төв байгуулах	30,000,000.00	4/10/2012	27,800,000.00
27	Д.Бадамгарав	Сүхбаатар	Оймсны үйлдвэр байгуулах	20,000,000.00	4/10/2012	7,257,000.00
28	З.Баярсүрэн	Сант	Хүлэмжийн аж ахуй байгуулах	20,000,000.00	4/12/2012	15,863,000.00
29	А.Лхагва-Очир	Шаамар	Гоо сайхны газар байгуулах	2,500,000.00	4/16/2012	2,500,000.00
30	Б.Идэрцог	Сүхбаатар	Ногоо даршлах цех байгуулах	15,000,000.00	4/18/2012	7,665,000.00
31	С.Отгонбаяр	Сүхбаатар	Талх нарийн боовны цех байгуулах	7,000,000.00	5/15/2012	100,000.00
32	Б.Сэргэлэнбаатар	Сүхбаатар	Пено блокны үйлдвэр байгуулах	35,000,000.00	5/21/2012	10,900,000.00
33	Б.Батцэцэг	Сүхбаатар	Гахайн утсан махны үйлдвэр байгуулах	20,000,000.00	5/21/2012	19,500,000.00
34	А.Баярмаа	Баруунбүрэн	Цайны газрын өргөтгөл	12,000,000.00	5/22/2012	12,000,000.00
35	М.Болор-Эрдэнэ	Сүхбаатар	Ноосон цамц нэхмэлийн үйлдвэр байгуулах	10,000,000.00	5/22/2012	7,000,000.00
36	М.Баярмаа	Шаамар	Хүнсний ногооны вакумжуулах үйлдвэр	50,000,000.00	7/4/2012	49,000,000.00
37	Л.Чулуун	Сүхбаатар	Блокны үйлдвэр байгуулах	10,000,000.00	7/4/2012	7,000,000.00
38	Т.Шинэхүү	Сүхбаатар	Чацаргана боловсруулах үйлдвэр байгуулах	20,000,000.00	7/5/2012	4,800,000.00
39	С.Дамба	Мандал	Сүү боловсруулах үйлдвэр байгуулах	35,000,000.00	7/5/2012	35,000,000.00
40	Я.Дархандаваа	Жавхланта	Төмс хүнсний ногоо тариалах	4,000,000.00	10/26/2012	3,900,000.00
Нийт: Хувь хүнээс авах авлагын үлдэгдэл						539,757,252.00
<b>Бүгд дүн</b>						<b>1,520,999,912.00</b>